

ДАШИНЧИЛЭН СУМЫН ТАНИЛЦУУЛГА

Булган аймгийн Дашинчилэн сум нь хуучнаар Үйзэн гүний хошуу ба Богдын их шавийн Эрдэнэ-Номун хааны отогт харъяалагдаж байсан. Үйзэн гүний хошуу нь 1758 онд Зоригт вангийн одоогийн Эрдэнэсант, Бүрэн хошуунаас Түшээт хан Чахундоржийн дүү Шидишир бэйлийн ач Сандагдоржийн эзэмшил болон тасарсан. Ардын хувьсгалаас хойш 1924 онд Засгийн газрын түшмэл Жамъян хэмээх хүн ирж шинэ хошуу, сум 10 гэрийн захиргааг байгуулан “Чин ширээт Монгол уулын хошуу” хэмээн нэрлэсэн. Хожим нь Яргайт, Доргонт гэж нэрлээд Даргаараа Соном зангийг сонгосон түүхтэй. Засаг захиргааны дахин хуваарилалтаар 1931 онд Дашинчилэн сум нэртэйгээр Төв аймгийн харьяанд байгуулагдаж 1938 оны 10 дугаар сард Сүүжийн голд нүүлгэн авчирч, төвийг нь Сүүж гэж нэрлэсэн. 1942 оны Засаг захиргааны хуваарилалтаар Булган аймагт харъяалагдах болжээ.

Өнөөгийн Дашинчилэнчүүд бидний амьдран суугаа нутаг бол Монгол туургатны үүсч бүрэлдэх үеэс уугуул газар нутгийн нэг хэсэг байсан бөгөөд эх түүхийн мөчлөг бүхэнд тэнд оршин тогтнож байсан аймаг, улсын түүхэн үйл явдлуудтай гүн гүнзгий холбоотой болохыг Хангидайн хадны сүг зураг, Арслантын хадны сүг зураг, Цогт хун тайжийн цагаан балгасын туурь, Цогт тайжийн гэрэлт хөшөө, Киданы үеийн Хар бухын балгас, Харуулын цамхаг, Бичигтийн шургуулганы бичээс, Замын сэртэн, Чинтолгой зэргээс харж болно.

Манай нутаг эх түүхийн үнэт өвийн нэг хэсэг байгаад зогсохгүй халуун эх орончид, анхдагчид тэргүүтэй олон алдар цуутны өлгий юм.

Манжийн түрэмгийллийн эсрэг анхлан тэмцэгчдийн тэргүүн, халуун эх оронч, их соён гэгээрүүлэгч, яруу найрагч Цогт хун тайж, Монгол улсын анхны Алдарт гавъяат хуурч Д.Түдэв гүн, Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, төрийн шагналт зохиолч Сономын Удвал, ардын аж ахуйтны дундаас төрсөн анхны Хөдөлмөрийн баатар Дэнсмаагийн Бадгай, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Жаргалын Лувсандэндэв, Төрийн тэргүүн түшээ Монгол улсын анхны ерөнхий аудитор асан Лхамсүрэнгийн Жавзмаа, МУ-ын Ардын эмч, АУ-ы доктор, профессор Жамбалын Хатанбаатар, МУ-ын Ардын багш, Техникийн ухааны доктор, профессор Дэндэвийн Бадарч, УИХ-ын гишүүн, Аж үйлдвэрийн гавъяат ажилтан, нэрт бизнесмэн Цэдэнгийн Гарамжав, Бүгд Найрамдах Беларусь Улсад суух анхны Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батсүхийн Баярсайхан, Батлан хамгаалахын дэд сайд Батсүхийн Баярмагнай, Цахим хөгжил харилцаа холбооны дэд сайд Батцэнгэлийн Болор-Эрдэнэ, Батлан хамгаалахын

Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Жавзмаагийн Болдбаатар, ОБЕГ-ын тэргүүн дэд бөгөөд штабын дарга, бригадын генерал Жамсранжавын Чүлтэмсүрэн тэргүүтэй үе үеийн алдартнууд, анхдагчид манай нутгаас төрөн гарчээ.

Дашинчилэн сумаас төрөн гарсан гавьяатуудыг дурьдвал: Хүний гавьяат эмч Цэрэндондогийн Цэрэндорж, Монгол улсын Гавьяат жүжигчин Банзарын Баасанжав, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Содномдоржийн Бавуусүрэн, Монгол улсын гавьяат жүжигчин Дашдамбын Ширмэнтүяа, Монгол улсын анхны эмэгтэй Гавьяат тээвэрчин Балжиннямын Осоржамаа, Урлагийн гавьяат зүтгэлтэн Дашцэрэнгийн Гунгаа, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, АШУ-ы доктор, профессор Мятавын Туул, Соёлын гавьяат зүтгэлтэн Балдандоржийн Ганчимэг, Гавьяат эдийн засагч Зундуйдаваа Цэрэнчимэг, Урлагийн гавьяат зүтгэлтэн Балдандоржийн Ганхуяг, Монгол улсын Гавьяат дасгалжуулагч Галдандагвын Базарсүрэн, Соёлын гавьяат зүтгэлтэн Сэрээтэрийн Дагвадорж, Монгол улсын Гавьяат жүжигчин Төмөрийн Оюунцэцэг, Гавьяат тамирчин Дэндэвийн Амгаа, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Батсүхийн Хандмаа, Гавьяат хуульч, төрийн албаны зөвлөлийн гишүүн асан Багаажавын Өнөбаатар, Гавьяат багш Буянгийн Дулмаа, Монгол улсын Гавьяат жүжигчин Санжаагийн Баянмандах нар төрөн гарсан байна.

Самбо бөхийн олон улсын мастер Д.Амгаа, Д.Галдандагва, Монгол улсын онц тээвэрчин Улсын начин Р.Раднаабазар, Улсын начин С.Ганхуяг, ҮҮХМ Д.Чимэдцээ, Д.Батсайхан, Чөлөөт бөхийн спортын мастер Б.Даваадорж, Сумо бөхийн ОУХМ Б.Оролзод, Боксын спортын мастер Л.Даваадорж, МЗЭ-ийн шагналт зохиолч О.Цэндсүрэн, Шатрын спортын мастер Ш.Дэчин, шатрын дэд мастер Аймгийн арслан У.Чойдог, Аймгийн арслан Б.Буянтай, Ц.Очиржав зэрэг олон сайчууд Дашинчилэн сумын хөндий толгодын дунд хүн болж, алдар суу залгасан юм.

Дашинчилэн сум нь Улаанбаатар хотоос 227км, Булган аймгийн төвөөс 147 км зайд байрладаг. Төв аймгийн Заамар, Эрдэнэсант сум, өөрийн аймгийн Бүрэгхангай, Баяннуур, Рашаант, Гурванбулаг, Хишиг-Өндөр сумдтай хиллэдэг. Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангайн нурууны зүүн хойд салбар уулсын дэд мужид хамрагдаж Орхон-Туулын сав дагуу бэсрэг уулт хээрийн бүсэд оршдог. Далайн төвшнээс дээш 948-1601 метрт өргөгдсөн хамгийн нам цэг нь нутгийн хойд хэсэг Хар бухын голын хөндий 948 м, хамгийн өндөр цэг нь төв хэсэгт Лах уул 1601 метрийн өндөртэй. Нам бэсрэг уулсын хооронд Бүрдийн дэнж, Хаяа, Бэлчэрийн хөндий, Хаахын хөндий, Бүдүүний хөндий, Хар бух голын хөндий, Яргайтын хөндий, Шийр, Далын хөндий зэрэг олон сайхан өргөн уужим хөндийнүүд оршино. Сумын нутаг

дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр буюу мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

2025 оны 3-р улирлын байдлаар Хараат, Лах, Доргонт, Сүүж 4 багт 915 өрх, 2949 хүн оршин сууж байна. Нийт хүн амын 1084 хүүхэд, 488 ахмад настан, эдийн засгийн идэвхитэй 1377 иргэн байна. Дашинчилэн сум нь 440 малчин өрх, 190 мал бүхий өрхтэй, малчдын тоо 720, нийт 171090 толгой малтай.

Газар тариалан

2024 онд Сумын хэмжээнд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Өрхтий трейд ХХК нь 850 тн улаанбуудай, 210 тн рапс, 15 тн овьёос хураан авсан. Сумын нэгдсэн ногооны талбай болон өрхийн тариалан эрхлэгчид 16.3 тн төмс, 16.3 тн хүнсний ногоо, “Сорог төгөл” ХХК нь 28.1 га талбайгаас 11 тн чацаргана хураан авч, нийт 195.9 сая төгрөгний борлуулалт хийсэн байна.

Сумын хэмжээнд бүртгэлтэй нийт 119 аж ахуй нэгж, байгууллага байна. Үүнээс 6 төрийн байгууллага, 8 салбар, 55 хоршоо, 2 төрийн бус байгууллага, 5 холбоо байгаагаас 60 буюу 50.4%-ийг идэвхитэй үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж, байгууллага эзэлж байна. Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагын тоо өмнөх оноос 1.3%-иар өссөн байна.

2025 ОНЫ 3-Р УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ

Дашинчилэн сумын Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын захирамжаар баталсан журам болон иргэдээс тавьсан асуудалтай холбоотой хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичиг, дүрэм журмыг баримтлан ажиллаж байна.

Дашинчилэн сумын Засаг даргын Тамгын газар болон Төр төсвийн байгууллагад 2025 оны 3-р улирлын байдлаар иргэд олон нийтээс 80 өргөдөл, гомдол ирсэн байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хуралд – 0

Засаг даргын Тамгын газарт –62

Цагдаагийн албанд – 0

Эрүүл мэндийн төв –7

Ерөнхий боловсролын сургуульд –11

Нарлаг цэцэрлэгт- 0

Соёлын төвд-0

2024 оны 3-р улирлын байдлаар Сумын Засаг даргын Тамгын газарт хандаж иргэдээс нийт 62 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд үүнийг харъяалах мэргэжилтэн албан тушаалтнаар ангилан авч үзвэл Засаг дарга болон Засаг даргын орлогч дарга нарт хандаж газар өмчлөх тухай, газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах тухай, Хадлангийн газар хүссэн, Ногоон ази ТББ-ын тухай, Газрын захирамжинд нэр оруулах тухай, цалин хөлс олгуулах тухай, Авто зам дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах тухай, иргэний бүртгэлийн овог нэр өөрчлөлт болон хүүхэд үрчлэлт, мод тарих тухай, Эмийн сангийн өрөөг түрээслэх тухай, ажлын байр болон ахуй үйлчилгээний газарт өрөө түрээслэх тухай, ЕБС-ийн захиралтай холбоотой, канон зураг, хэвлэлийн үйл ажиллагаа явуулах тухай, Гэр шатсан тухай 62 өргөдөл, гомдол ирсэнийг холбогдох хууль журамд заасны дагуу шилжүүлэн шийдвэрлэж ажиллаж байна.

ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2025 оны 3 дугаар улиралд иргэдээс Дашинчилэн сумын байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /Хувиар/
		Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
Сумын ЗДТГ	62	43	-	2	17	69
Ерөнхий боловсролын сургууль	11	11	-	-	-	100
Цэцэрлэг	-	-	-	-	-	
Эрүүл мэндийн төв	7	6	-	-	1	86
Соёлын төв	-	-	-	-	-	-
Сумын нийт дүн	80	60	-	2	18	85%

Хүснэгт №2

2024 оны 3 дугаар улиралд иргэдээс Дашинчилэн сумын байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр/

Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Үүнээс:				
		Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
Сумын ЗДТГ	62	62	-	-	-	-
Ерөнхий боловсролын сургууль	11	11	-	-	-	-
Цэцэрлэг	-	-	-	-	-	-
Эрүүл мэндийн төв	7	7	-	-	-	-
Соёлын төв	0	0	-	-	-	-
Сумын нийт дүн	80	80	-	-	-	-

Хүснэгт №3

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА

1	Дашинчилэн сум	Нийт 80 өргөдлөөс 1. Хүсэлт – 79 / 99 %/ 2. Гомдол 1 / 1%/ 1. Газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгуулах тухай хүсэлт-1 2. Ахуй үйлчилгээний төвд өрөө түрээслэх тухай- 9 3. Удирдах албан хаагчтай холбоотой гомдол-1 4. Ахуйн объектын галын улмаас гэр шатсан тухай-1 5. Газар өмчлөх, газар хүссэн тухай-37 6. Ногоон ази ТББ-ыг эзэнтэй болгох тухай-1 7. Газрын захирамжинд нэр оруулах тухай-1 8. Цалин хөлс олгуулах тухай-1 9. Авто зам дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах тухай-1 10. Иргэний бүртгэлийн овог нэр өөрчлөх, хүүхэд үрчлэхтэй холбоотой -3 11. Мод тарих газар хүссэн тухай-1 12. Шинээр ашиглалтад орох дотуур байр, Эрүүл мэндийн төвд ажилд орох тухай хүсэл-18 13. Дотуур байранд хүүхэд оруулах тухай хүсэлт-1 14. Конан зураг, хэвлэлийн үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт -1 15. Дугуй засвар зам хооронд гарц гаргах тухай -1 16. Гэр нурсан болон шагайн харвааны зардалд дэмжлэг хүссэн -2
---	----------------	--

ТАЙЛАН ГАРГАСАН

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТЦЭЦЭГ